

СОЁМБО МЭДЭЭ

"СОЁМБО" РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.03.16 №09 (09)

ҮЙЛ ЯВДАЛ

"МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ" ДУУ ТӨРЛӨӨ



Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Харанга" хамтлагийн уран бүтээлчдийг

хүлээн авч уулзлаа.

Уулзалтын эхэнд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр түүхт ойг угтаж салбарын хэмжээнд хийж байгаа ажлуудаас дурдаад,

Зэвсэгт хүчний өнөөгийн байдал, ололт амжилтын талаар товч мэдээлэл өгөв. Үүний дараа "Харанга" хамтлагийн уран бүтээлчид Зэвсэгт хүчний түүхт ойд зориулсан "Монгол

Улсынхаа төлөө зүтгэе" нэртэй шинэ уран бүтээлээ сонгосон бөгөөд Батлан хамгаалахын сайд "Зуун жилийн ойн босгон дээр туурвисан уг бүтээл нь салбарын хэмжээнд гэлтгүй Монголын ард түмний сэтгэлийг хөндөх сайхан дуу болжээ. Та бүхний цаашдын уран бүтээлд амжилт хүсье" гэсэн юм.

"Харанга" хамтлагийн ахлагч МУГЖ Ц.Энхманлай "Манай хамтлагийн гишүүд бүгд Зэвсэгт хүчинд ахлагч цолтой алба хаасан. Хэдий бид өдгөө 60 гаруй настай ч уран бүтээлээ туурвисаар жавхаатай яваа нь цэргийн албаны ач гавьяа гэж боддог. Эр хүн цэрэгт явснаар тэсвэр хатуужлыг олж авдаг. Зэвсэгт хүчний 100 жилийн ой гэдэг нь бидний хувьд хамгийн үнэ цэнтэй баяр учраас БХЯ-тай хамтран ажиллах санал тавихад бид талархалтайгаар хүлээж авсан юм. Уг ажлын хүрээнд хамтлагийн гитарчин УГЗ Ц.Чулуунбат үг, аяыг нь бичиж, ЦДБЭЧ-ийн уран бүтээлчидтэй хамтран энэ дуугаа өлгийдөн аваад удаагүй байна. Ирээдүйд эр хүн бүрийн дуулах дуртай жагсаалын дуу болно хэмээн найдаж байна" гэв.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-1°C	-12°C

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
41°C	24°C

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
16°C	4°C

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,845.0	2,858.0
EUR	3,382.0	3,448.0
CNY	436.50	441.00
RUB	38.04	39.81
JPY	25.86	26.54
KRW	2.45	2.57

КОВИД-19 МЭДЭЭ

ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН	122
НИЙТ БҮРТГЭГДСЭН	4083
ЭДГЭРСЭН	3031
НАС БАРСАН	8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

ШИНЭЭР НЭМЭГДСЭН	11
ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	246
ЭДГЭРСЭН	920

ӨРНИЙН ЗУРХАЙ

2021.03.16 /МЯГМАР ГАРАГ/

ХАВРЫН ДУНД ЦАГААГЧИН ТУУЛАЙ САРЫН ТАВАН ШАР ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулвал:
Эд мал баялаг төгөлдөр болно
Наран ургах, шингэх:
07.03-18.58

Барилдлага: Хүчин төгсөх Шүтэн барилдлага: Төрөн түгэхүй Суудал: Отгоргүй

Аргын тооллын 3 сарын 16, Ангараг гараг. Билгийн тооллын 3, Шийдэм одтой, харагчин гахай өдөр. Өдрийн наран 7 цаг 03 минутад мандан, 18 цаг 58 минутад жаргана. Тухайн өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, нялхсын хурим хийх, сүм дуганыг сэргээх, отгоргүйн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худга гаргах, гөлөг тэжээх, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, гахай болой. Хол газар яваар одогосод зүүн хойш мөрөө гаргавал зохистой. Дашнямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эд малтай баялаг төгс болно.

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ЭНХИЙГ САХИУЛАГЧИДТАЙ ЦАХИМ УУЛЗАЛТ ХИЙВ



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс болон Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад үүрэг гүйцэтгэж буй Монгол

Улсын Зэвсэгт хүчний цэргийн багуудын бие бүрэлдэхүүнтэй цахим уулзалт хийлээ.

Уулзалтын эхэнд БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын "UNMISS" ажиллагаанд

үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн багийн захирагч, хурандаа Д.Энхбаатар, Афганистан Улсад явагдаж буй "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагааны цэргийн багийн захирагч, дэд хурандаа М.Түвшинжаргал, мөн ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэж буй цэргийн багийн захирагч, дэд хурандаа Г.Амартүвшин нар үүрэг гүйцэтгэлт, ажиллагааны газар орны цагийн байдлын талаар тус тус илтгэлээ.

Үүний дараа Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр "Юуны өмнө дэлхий нийт "COVID-19" цар тахалтай тэмцэж байгаа амаргүй цаг үед Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчид Төр, засгийнхаа шийдвэрээр дэлхийн энх тайвны үйл хэрэгт хувь нэмрээ оруулан үүргээ нэр төртэй гүйцэтгэж

байгаад Батлан хамгаалахын сайдын хувьд сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлэе. Ажиллагааны газар оронд үүсэж байгаа нөхцөл байдалд маш мэдрэмжтэй хандаж, өдөр тутмын мэдээллүүдийг нэгтгэн цэргийн алба хаагчдаа цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээг зохион байгуулалтын өндөр түвшинд авч хэрэгжүүлэх хэрэгтэй" гээд цэргийн багуудын захирагч, удирдлагын бүрэлдэхүүнд албан даалгавар, үүрэг чиглэл өглөө. Уулзалтын төгсгөлд энхийг сахиулагчдад хандан Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс болон хувиасаа чин сэтгэлийн амжилт хүсэж, удахгүй тохиох Зэвсэгт хүчний 100 жилийн ойн мэндийг дэвшүүлсэн юм.

ХУРАНДАА ЦОЛ ОЛГОЛОО

ҮБХИС-ийн Ар талын хэлтсийн дарга, дэд хурандаа Ж.Давааноров, нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабын дарга, дэд хурандаа Л.Цэрэгбаяр, ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Н.Гантөмөр, Ажиллагааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Н.Цэцэнхүү, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн ажиллагааны удирдлагын ахлах офицер, дэд хурандаа Ч.Буянзаяа, Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын Цэргийн мэргэжлийн удирдлагын хэлтсийн дарга, дэд хурандаа Т.Батсайхан, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн захирагч, дэд хурандаа Ш.Цэрэнбат, Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа Д.Шинэбаяр, Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа Н.Эрдэнэбаяр, нийслэлийн Онцгой байдлын газрын Гал түймэртэй тэмцэх хэлтсийн дарга, дэд хурандаа



Л.Тэгшбаяр, нийслэлийн Баянзүрх дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Эрдэнэбат, Дотоод хэргийн их сургуулийн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа Х.Мягмаржав нарт албан тушаалын зэрэглэлийн хурандаа цол олголоо. Хошууч генерал Д.Ганзориг

шинэхэн хурандаа нарт баяр хүргэж хэлсэн үгэндээ "Түүхт 100 жилийн ойн босгон дээр эрхэм цол хүртсэнд та бүхэнд баяр хүргэе. Хурандаа хэмээх энэ эрхэм цолыг хүртэхэд таны албаны төлөө хүчин чармайлт, хичээл зүтгэл, хамт олон, гэр бүлийн тань дэмжлэг байгаа. Цол хүртэхээс

илүү цолныхоо нэр хүндийг даана гэдэг хамгийн том шалгуур үзүүлэлт. Үүрэг хариуцлага, ачаа даах чадвараараа бусдадаа үлгэрлэж, харилцаа, хүндлэлээрээ хамт олондоо үнэлэгдэх учиртай юм шүү. Та бүхний цаашдын ажил, албанд өндөр амжилт хүсье" гэсэн юм.

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100

1000 ГАРУЙ ЦУГЛУУЛГА ДЭЛГЭГДЛЭЭ



солилцсон ач холбогдолтой арга хэмжээ болсон гэдгийг онцолж байлаа.

Мөн "Мөрдөстэй цуглуулагчид" НҮТББ-ын нарийн бичгийн дарга, дэд хурандаа А.Гэрэлт-Од "Бидний хувьд байгуулагдсан цагаасаа эхлэн олон ажил төлөвлөсөн ч цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан зарим төлөвлөсөн арга хэмжээ хойшлогдсон. Анх удаа зохион байгуулж буй энэхүү үзэсгэлэн нь тэдгээр арга хэмжээний нэг нь. "Мөрдөстэй цуглуулагчид" НҮТББ-аас Ардын хувьсгалын 100 жилийн ойгоор бусад төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын ижил төрлийн хобби, сонирхолтой холбоо, алба хаагчидтай хамтран үзэсгэлэн зохион байгуулах төлөвлөгөөтэй байна. Бидний үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл авахыг хүсвэл "Мөрдөстэй цуглуулагчид" фэйсбүүк группт нэгдээрэй. Мөрдөстнүүддээ бид үргэлж нээлттэй" гэв.

ЗХЖШ болон "Мөрдөстэй цуглуулагчид" НҮТББ хамтран "Мөрдөстэй цуглуулагч-2021" үзэсгэлэнг өчигдөр зохион байгууллаа. Зэвсэгт хүчний 100 жилийн ойг угтан зохион байгуулсан тус үзэсгэлэнд Зэвсэгт хүчний генерал, офицер, ахлагч нарын төлөөлөл 14 алба хаагч 1000 гаруй цуглуулгаараа оролцоо. Цамхаг, заан, тэмээ,

дельфин, хундага, түлхүүрийн оосор зэрэг чамин хийцтэй өвөрмөц дурсгалын зүйлсээс гадна цэргийн зэвсэг, техникийн модель, медалион, орон орны зоосон болон цаасан мөнгөн дэвсгэртүүдээс бүрдсэн "Мөрдөстэй цуглуулагч-2021" үзэсгэлэнд оролцогчид цуглуулгаа хэрхэн арвижуулах, арчилж хамгаалахад юунд анхаарах талаар туршлага

ОНЛАЙН ТЭМЦЭЭНД БАГШ НАР АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



Олон улсын "CESIM-Global-Challenge" симуляци онлайн тэмцээнд ҮБХИС-ийн багш нар амжилттай оролцлоо. Монгол Улсын эдийн засаг, бизнесийн хөтөлбөр хэрэгжүүлдэг их, дээд сургуулийн багш нарын дунд анх удаа зохион байгуулагдсан тус тэмцээнд ҮБХИС-ийн ЭЗМТ-ийн ахлах багш Ш.Гантуяа, багш, профессор Д.Энхчимэг, дэд профессор Б.Мөнхжаргал, Д.Гандолгор, Б.Баянхишиг нар сургууль, тэнхимээ төлөөлөн оролцсон юм. Симуляци буюу сургалтын шинэ цахим модулиар Монгол Улсын эдийн засаг,

бизнесийн чиглэлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг их сургуулиудын багш нарын 8 баг гар утасны глобал зах зээлд /АНУ, Ази, Европ/ 10 үеийн турш шийдвэр гарган 8 өдөр буюу 191 цаг тасралтгүй өрсөлдөв.

Тэмцээн англи хэлээр явагдаж, глобал зах зээлийн эрэлтийн төлөвлөлт, үйлдвэрлэлийн төлөвлөлт, үйлдвэрлэл, маркетинг, хүний нөөц, R&D, нийгмийн хариуцлага, ложистик, татвар, санхүүгийн хүрээний иж бүрэн шийдвэр гаргаж, АНУ, Ази, Европын зах зээлд гар утасны технологийн компанийхаа

стратегияр өрсөлдсөн юм. Өнөөдөр дэлхийн 6 тивийн 50 гаруй орны 500 гаруй сургалтын байгууллага, бизнесийн салбарт өргөн хэрэглэгдэж байгаа "CESIM-Business-Simulation"-ийг Монгол Улсад амжилттай хэрэгжүүлэх эхлэлийг ийн ҮБХИС-ийн багш нар тавьлаа. Хөтөлбөрийн сургалтад үнэтэй хувь нэмэр оруулж чадахуйц их зүйл сурч мэдсэн, дэлхийн хөгжилтэй хөл нийлүүлэн алхах боломж байгааг олж харсан, цаашид сурч, хөгжих тэмүүлгийг бий болгосон ач холбогдолтой тэмцээн болсныг багш нар онцлов.

100 ЖИЛИЙН ОЙГООР ШИНЭ ТОГЛОЛТОО ТОЛИЛУУЛНА

Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын уран бүтээлчид орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, "Монгол цэргийн өдөр"-өөр үзэгч олонд толилуулах Хүндэтгэлийн тоглолт болон чуулгын гоцлол уран бүтээлчдийн теле концертын бэлтгэл ажлыг хангаж, бэлэн болгоод байна.

Ойн өдрүүдэд МҮОНТВ, ТВ8, ТВ5, UBS, TV25, NTV, C1 зэрэг арав гаруй телевизийн сувгаар Зэвсэгт хүчний 100 жилийн ойн Хүндэтгэлийн тоглолт, "Эх орны цэрэг" яруу найргийн наадам, "Эх орны дуудлага" гоцлол уран бүтээлчдийн теле концерт болон чуулгын уран бүтээлчдийн тоглолт, уран бүтээлүүд өргөнөөр цацагдах болно.

Мөн Зэвсэгт хүчний түүхэн



их ойгоо тохиолдуулан хийсэн "Мартах учиргүй", "Амрагийн дуу", "Эх орон танаа", "Миний залуу нас цэрэг явлага" зэрэг чуулгын уран бүтээлчдийн клипүүд шил шилээ даран гарч, үзэгч олондоо хүрч эхэллээ.

Дашрамд сонирхуулахад, Зэвсэгт хүчний 100 жилийн ойн Хүндэтгэлийн тоглолт нь Монгол Ардын Хувьсгалт Цэрэг,

Ардын арми, энх цагийн бүтээн байгуулалтад онцгой үүрэг гүйцэтгэсэн цэрэг дайчид, орчин цагийн Зэвсэгт хүчний түүхийг урлагийн бүтээлээр дамжуулан харуулсан өгүүлэмжтэй бөгөөд ЦДБЭЧ-ын энэхүү тоглолтод Төрийн соёрхолт "Харанга" хамтлагийн уран бүтээлчид оролцож, хамтарсан шинэ уран бүтээл туурвисан билээ.

ЗЭВСЭГТ ХҮЧИН-100

ТА Ч БАС НЭГДЭЭРЭЙ



"Би жэндэрийн хэвшмэл ойлголтын эсрэг БАЙНА" байгаа юм. Жэндэрийн тогтсон хэвшмэл буруу ойлголт, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтын эсрэг, бүгдээрээ тэгш эрх, тэгш оролцоотой нийгмийг бүтээхийн төлөөх "Би жэндэрийн хэвшмэл ойлголтын эсрэг БАЙНА" уриатай аянд Батлан хамгаалах салбарын алба хаагч та ч бас нэгдээрэй.

Жэндэрийн тогтсон хэвшмэл буруу ойлголт, тэгш бус байдал, ялгаварлан гадуурхалтын эсрэг, бүгдээрээ тэгш эрх, тэгш оролцоотой нийгмийг бүтээхийн төлөөх "Би жэндэрийн хэвшмэл ойлголтын эсрэг БАЙНА" уриатай аянд Батлан хамгаалах салбарын алба хаагч та ч бас нэгдээрэй.

ЦАХИМ ШУУДАНД

ХУГАЦААТ АЛБАНЫ ДАЙЧИД БУУДЛАГА, ГРАНАТ ШИДЭЛТЭЭР ӨРСӨЛДӨВ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас Зэвсэгт хүчний 167, Хилийн цэргийн 0131, 0166 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдын дунд буудлага, гранат шидэлтийн тэмцээнийг энэ сарын 12-ны өдөр зохион байгууллаа. Тус тэмцээн хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн хэргийн мэдлэг, дадлагыг нэмэгдүүлж, сургалт бэлтгэлийн чанар, үр дүнг дээшлүүлэх зорилготой бөгөөд анги тус бүрээс 10 байлдагч оролцож цэц мэргэн,

ур чадвараа сорин өрсөлдсөн юм. Гранат шидэлтийн төрөлд байлдагч Г.Сумъяадорж (167), түрүүч Ш.Шинэхүү (0166), түрүүч М.Алтангэрэл (0166) нар эхний 3 байрыг эзэлж, тусгай байрт байлдагч Б.Багахүү (0166), байлдагч Ш.Батцэрэг (0131) нар шалгарав.

Буудлагын төрөлд байлдагч М.Эрдэнэдалай (0131), байлдагч Г.Баяржавхлан (167), байлдагч И.Сүхбат (167) нар эхний байруудад шалгарч, тусгай байрыг дэд түрүүч С.Ууганбаяр (0166), байлдагч Б.Пэрэнлэйдорж (167) нар эзлэн "Онц буудагч" тэмдгээр шагнууллаа.

Дэд хурандаа Д.УЛАМБАЯР

ИХ ГОВИЙН ГАРНИЗОНЬХОН ЖИГДРЭЛТЭЭ ХАНГАЛАА



Долоо хоногийн хугацаатай хээрийн гаралтыг Сургалтын төвийн районд явууллаа.

Энэ үеэр жолоодлого, буудлага, харвалт болон "Хүч нэмэгдүүлсэн мотобуудлагын рот давших байлдааныг бэлтгэж,

явуулах" сэдвээр байлдааны буудлагатай тактикийн хээрийн сургуулийг 3 үе шаттай амжилттай зохион байгуулж, салбарын жигдрэлтийг бүрэн хангаж, сургууль өмнөө тавьсан зорилгоо бүрэн биелүүллээ.

Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ



СОЁМБО СОНИН

"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор
Хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо" сонини редакцал бэлтгэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018
И-мэйл хаяг:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029